

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	5
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.10. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	9
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	10
2.12. Шилэн дансны мэдээлэл	10
2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	10
2.14. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10
3. Менежментийн захидал	11
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	12
4.4.1 Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан	12
4.2 Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан	14
4.3 Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан	15
4.4 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан.....	16
4.5 Аудит хийсэн 2019 оны зорилтот түвшингийн үзүүлэлтийн биелэлт	18
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨХК	Төрийн Өмчит Хувьцаат компани



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

“ДУЛААНЫ ХОЁРДУГААР
ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
С.БЯМБААХҮҮ ТАНАА

2020.03.13 № 06/839
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу “Дулааны хоёрдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

“Дулааны хоёрдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайланг Нягтлан бодох бүртгэлийн стандарт болон бусад хууль, тогтоомжийн дагуу материаллаг алдаагүй, үнэн бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Дулааны хоёрдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага


“Дулааны хоёрдугаар цахилгаан станц” ТӨХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



2. Аудитын тайлан

2.1. Оршил

“Дулааны хоёрдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг “Дулааны хоёрдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал С.Бямбаахүү Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох бүртгэлийг сайжруулах зөвлөмжийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Дулааны хоёрдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

“Дулааны хоёрдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон НББОУС, СТОУС түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

“Дулааны хоёрдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС, болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 11 дүгээр сарын 14-өөс 2020 оны 3 дугаар сарын 12-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 3 дугаар сарын 13-ны өдөр эцэслэн баталгаажуулж, “Дулааны хоёрдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар Нийслэл аудит ХХК-ын чанарын хяналтын менежер С.Сэрчхорол, аудитор Д.Ариунбулган, ахлах шинжээч Д.Чулуунбаатар, аудиторын туслах Ц.Гантуяа нар хариуцан хэрэгжүүлэв.

“Дулааны хоёрдугаар цахилгаан станц” ТӨХК нь 2019 оны санхүүгийн тайланг Нийслэл аудит ХХК-д 2020 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн 01/54 дугаар албан бичгээр ирүүлсэн боловч төсвийн тухай хуульд заасан цагалбарт хугацааг 12 хоног хоцроосон.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

“Дулааны хоёрдугаар цахилгаан станц” ТӨХК нь “Найдвартай эрчим хүч, Шинэ технологи, Өөдрөг амьдрал” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилгоо тодорхойлон ажилладаг байна.

“Дулааны хоёрдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2012 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 5 дугаар тогтоолын хавсралтад үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэх
- Цахилгаан, дулааны эрчим хүчийг дамжуулах, түгээх, борлуулах

Тайлант хугацаанд компанийн санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”
- Нийгмийн даатгалын тухай хуулиар ажил олгогч болон даатгуулагчаас төлөх шимтгэлийн хувийг 0.5 хувиар нэмэгдүүлсэн;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд заасан хөнгөлөгдөх татварын хэмжээг татвар ногдуулах орлогын хувь хэмжээнээс хамаарч өөрчлөлт орсон

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус “Дулааны хоёрдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

“Дулааны хоёрдугаар цахилгаан станц” ТӨХК нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “UNICUS” программ хангамж ашигладаг байна.

“Дулааны хоёрдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн дотоод хяналтын эрсдлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар “Дулааны хоёрдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитыг төлөвлөлтийн үе шатанд 19 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшнийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Нийт орлого нь үйл ажиллагааны цар хүрээг илтгэх тохиромжтой гэж үзэн суурь үзүүлэлтээр сонголоо.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 22,542.7 сая төгрөгөөс тооцон 225.4 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 248.6 сая төгрөгөөр тогтоосон нь 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн сонгосон суурь үзүүлэлтээс тооцсонтой холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

“Дулааны хоёрдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 9,210.2 сая төгрөгөөр буюу 16.0 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/ сая төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	344.7	367.6	22.9
Авлага	1,151.3	1,796.6	645.3
Татвар, НДШ-ийн авлага	-	9.8	9.8
Бусад авлага	13.1	4.5	(8.6)
Бараа материал	1,121.4	1,388.2	266.8
Урьдчилж төлсөн зардал тооцоо	29.2	70.1	40.9
Үндсэн хөрөнгө	36,069.3	25,883.5	(10,185.8)
Биет бус хөрөнгө	18,804.5	18,803.0	(1.5)
Нийт хөрөнгө	57,533.5	48,323.2	(9,210.2)
Дансны өглөг	1,159.4	1,433.5	274.1
Татварын өр	80.3	40.9	(39.4)
НДШ-ийн өглөг		0.1	0.1
Урт хугацаат зээл	565.0	523.2	(41.8)
Өмч:-төрийн	1,821.3	11,797.5	9,976.2
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	10,792.1	10,176.9	(615.2)
Эздийн өмчийн бусад хэсэг	44,179.4	24,495.5	(19,683.9)
Хуримтлагдсан ашиг	(1,064.0)	(144.3)	919.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	57,533.5	48,323.2	(9,210.2)

Өмнөх оны үзүүлэлтээс авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, өмчийн дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна. Тухайлбал:

Авлага дансны 1,796.6 сая төгрөгийн үлдэгдэлд дулааны эрчим хүчний борлуулалтаас нийт 6 хэрэглэгчээс авах 26.4 сая төгрөг, “ДҮТ” ХХК-аас авах 1,769.1 сая төгрөг, “УБДС” ТӨХК-аас авах 1.1 сая төгрөгийн авлага зэрэг байна. Дээрх авлага нь тайлант жилийн эцэст үүссэн ба хугацаа хэтэрсэн, он удаан жилийн насжилттай авлага байхгүй бөгөөд тооцоо нийлсэн актаар баталгаажсан байна.

Татвар, НДШ-ийн авлага дансны үлдэгдэл өссөн нь ажиллагсдын хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж болон жирэмсэн амаржсаны тэтгэмжийн авлага нөлөөлсөн байна.

Бусад авлага дансны үлдэгдэлд бэлтгэн нийлүүлэгчээс авах авлага ярианы төлбөр, хэвлэлийн үнэ, шатахууны төлбөр зэрэг 2.3 сая төгрөг, “ДЦС-4” ТӨХК-аас авах СПОТ зах зээл дахь дулааны эрчим хүчний борлуулалт 1.8 сая төгрөг, ажилчдаас авах авлага 0.4 сая төгрөг зэрэг багтсан байна.

Бараа материалын 1,388.2 сая төгрөгийн үлдэгдэлд нүүрс, дулаан цахилгааны сэлбэг хэрэгсэл, шатах тослох материал, хангамжийн материал, сэлбэг хэрэгсэл, химийн материал, хөдөлмөр хамгааллын материал, аваарын нөөц зэрэг байна. Завсрын аудитаар өгсөн зөвлөмжийн дагуу агуулахад удаан хугацаагаар хадгалагдаж ашиглах боломжгүй болсон 84 нэр төрлийн 17,959.8 сая төгрөгийн үнэ бүхий бараа материалыг Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 22 тоот тогтоолын дагуу данс бүртгэлээс хассан байна.

Урьдчилгаа дансны үлдэгдэл өссөн нь мэргэжилтэй ажилтан бэлтгэх буюу давтан сургах сургалтын төлбөрийн урьдчилгаа төлбөр болон ажил үйлчилгээ гүйцэтгэсэн аж ахуйн нэгж байгууллагуудаас авах хойшлогдсон нэмэгдсэн өртгийн албан татварын тооцооны үлдэгдэл нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 10,185.8 сая төгрөгөөр буурсан нь 2019 онд ТӨБЗГ-ын 2019 оны 434 дугаар тогтоолоор “Таван толгойн түлш” ХХК-д Шахмал түлшний үйлдвэрийн барилга 7,098.7 сая төгрөг, тоног төхөөрөмж 2,609.0 сая нийт 9,707.7 сая төгрөгийн хөрөнгийг балансаас балансад шилжүүлсэн, ТӨБЗГ-ын 2019 оны 238 дугаар тогтоолоор 1,046.1 сая төгрөгийн ашиглалтын хугацаа дууссан, ашиглах боломжгүй хөрөнгийг акталсан мөн тайлант хугацааны элэгдлийн зардал зэргээс шалтгаалжээ. Эрчим хүчний сайдын 2019 оны 10-р сарын 04-ны өдрийн 245-р тушаалаар 2019 онд үндсэн тоноглолын их засвараар 24.5 сая төгрөгийн, туслах тоноглолын их засвараар 262.5 сая төгрөгийн, ТЗБАХ-ээр 1,576.3 сая төгрөгийн, хөрөнгө оруулалтаар 219.9 сая төгрөгийн нийт 2,083.2 сая төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн байна.

Өр төлбөр дансны үлдэгдэлд 2018, 2019 онуудын 26.1 сая төгрөгийн барьцаа хөрөнгө, нийт өр төлбөрийн 1.8 хувийг, бэлтгэн нийлүүлэгчдэд төлөх өр төлбөр 98.2 хувийг тус тус эзэлж байна.

Өр төлбөрийн үлдэгдэлд “Одкон холдинг” ХХК, “Юнайтад партс” ХХК, “СММ” ХХК, “Поверпүүл” ХХК, “Монхорус интернэшнл” ХХК зэрэг аж ахуйн нэгж байгууллагад өгөх баталгааны төлбөр 26.1 сая төгрөг, Монголын эрчим хүчний инженерүүдийн холбоо, Үндэсний аудитын газар, “Финтек БМ Ай” ХХК, “Мон Илч” ХХК зэрэг аж ахуйн нэгж байгууллагад өгөх гэрээний үлдэгдэл төлбөр 644.6 сая төгрөг, “ДҮТ” ХХК, “Багануур” ХХК, “Тэгш сайхан хүсэл” ХХК, ТӨБЗГ зэрэг аж ахуйн нэгж байгууллагад өгөх бусад өр төлбөр 762.8 сая төгрөг нийт 1,433.5 сая төгрөгийн өр төлбөр багтаж байна.

Дансны өглөгийн үлдэгдэл нэмэгдсэн нь худалдан авах ажиллагааны дагуу гэрээнд заагдсан гэрээний үлдэгдэл төлбөр болон баталгааны төлбөрийн өглөг үлдсэн нь нөлөөлсөн байна. Дээрх өглөг тооцоо нийлсэн актаар баталгаажсан болно.

Татварын байгууллагад өгөх өр төлбөр 40.9 сая төгрөг байгаа нь Нэг худалдан авагч /ДҮТ/-ээс авах авлагыг сарын сүүлд гүйлгээ хаасны дараа дансанд төвлөрүүлснээс үүдэн татварын өр үүсэхэд нөлөөлсөн байна.

УИХ-ын 2010 оны 72-р тогтоол, “Тогтоол хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Сангийн сайд, Эрдэс баялаг эрчим хүчний сайдын хамтарсан 2011 оны 276/300 дугаар тушаалыг үндэслэл болгон урт хугацаат дамжуулан зээлдүүлэх гэрээг 2012 оны 4-р сараас эхлэн урт хугацаат . Энэхүү төслийн зээлийн төлбөрийг 2032 оныг дуустал төлж барагдуулах ба урт хугацаат зээлийн үлдэгдэлд дээрх зээлийн үлдэгдэл дүн нөлөөлсөн болно.

Өмчийн дансны үлдэгдэл өссөн нь нэмэгдсэн нь “Дулааны хоёрдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 2019 оны 11 дүгээр сарын 8-ны өдрийн 11 дугаар тогтоолыг үндэслэн өмчийн дүнг 9,976.2 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн нь нөлөөлсөн байна.

Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны бууралт дахин үнэлсэн хөрөнгийг акталсантай холбоотой байна

Эздийн өмчийн бусад хэсэг дансны үлдэгдэл буурсан нь хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр 9,976.2 сая төгрөгөөр өмчийн дансанд шилжүүлж мөн 9,707.7 сая төгрөгийн хөрөнгө балансаас балансад шилжүүлсэн нь нөлөөлсөн байна.

2.9. Зорилтот түвшин, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д заасны дагуу зорилтын саналыг, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага нь энэ хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3-т “Төрийн өмчит хуулийн этгээд дагаж мөрдөх төлөвлөлт, ашиг орлогын хуваарилалтыг холбогдох байгууллагатай тохиролцон тогтоох” гэж заасныг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Эрчим хүчний яамны сайдын 2019 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн 245 дугаар тушаалаар Дулааны хоёрдугаар цахилгаан станц ТӨХК-ийн 2019 оны эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний шинэчилсэн төлөвлөгөөг 24,330.7 сая төгрөгийн орлоготой, 25,956.7 сая төгрөгийн зардалтай, 1,626.0 сая төгрөгийн алдагдалтай байхаар баталжээ.

Боловсруулсан цахилгаан эрчим хүч 159.2 сая квт/ц үйлдвэрлэхээс 158.9 сая квт/ц үйлдвэрлэж төлөвлөгөөг 99.8 хувиар, дотоод хэрэглээний цахилгаан эрчим хүч 20.4 сая квт/ц үйлдвэрлэхээс 20.0 сая квт/ц үйлдвэрлэж төлөвлөгөөг 98 хувиар тус тус биелүүлсэн. Цахилгаан эрчим хүч түгээлт 138.8 сая квт/ц үйлдвэрлэхээс 138.9 сая квт/ц буюу 100.1 хувиар, дулааны эрчим хүч түгээлт 212.2 мян.Гкал үйлдвэрлэхээс 232.5 мян.Гкал буюу 109.6 хувиар үйлдвэрлэлийг тус тус давуулан биелүүлсэн байна.

Зорилтот түвшний төлөвлөгөөгөөр цахилгаан эрчим хүчний борлуулалтын орлого 21,694.7 сая, дулааны эрчим хүчний орлого 2,467.9 сая, үйл ажиллагааны бус орлого 168.0 сая төгрөгөөр тус тус батлагдсанаас гүйцэтгэлээр цахилгаан эрчим хүчний орлого 21,830.1 сая төгрөг буюу 100.6 хувиар, дулааны эрчим хүчний орлого 2,850.5 сая төгрөг буюу 115.5 хувиар, туслах үйл ажиллагааны орлого 179.2 сая төгрөг буюу 106.7 хувиар тус тус биелсэн байна. Үүнээс цахилгаан эрчим хүчний орлого 135.4 сая, дулааны эрчим хүчний орлого 382.6 сая, туслах үйл ажиллагааны орлого 11.2 сая төгрөгөөр тус тус давуулан биелүүлж нийт дүнгээр 529.1 сая төгрөгөөр орлогын төлөвлөгөө давсан байна.

ЭХЗХ-ны 2019 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 285 дугаар тогтоолоор 2019 оны 07 дугаар сарын 1-ний өдрөөс тарифыг мөрдөхөөр нэмж баталснаар мөрдөж буй тариф оны эхнээс дунджаар 17.06 төгрөгөөр өссөн байна.

Цахилгаан эрчим хүч түгээлтийн хэмжээг 0.1 сая кВт.ц-аар илүү түгээснээр 15.7 сая төгрөгийн, дундаж тарифын зөрүүгээс 119.7 сая төгрөгийн, дулааны эрчим хүч түгээлтийн хэмжээг 20.3 мян.Гкал-аар илүү түгээснээр 248.9 сая төгрөгийн, дундаж тарифын зөрүүгээс 133.7 сая төгрөгийн илүү борлуулалт хийснээр нийт дүнгээр 529.1 сая төгрөгөөр орлогын төлөвлөгөө давсан байна.

Тайлант хугацаанд 25,956.7 сая төгрөгийн зардал гаргахаар төлөвлөснөөс 24,555.3 сая төгрөгийн гүйцэтгэлтэй буюу 1,401.4 сая төгрөгөөр хэмнэсэн боловч дараах зардлууд хэтэрсэн байна. Үүнд:

- Харуул, хамгаалалтын зардал 0.9 сая төгрөгөөр илүү зарцуулсан нь 2019 оны 08 дугаар сард хийсэн гэрээгээр хамгаалалтын гэрээт ажлын санхүүжилт нь ажилчдын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, үнийн өсөлттэй холбоотойгоор 2018 оноос 3.6 сая төгрөгөөр өссөнөөс шалтгаалсан байна.
- Диспетчерийн зардал 2.3 сая төгрөгөөр илүү зарцуулсан нь ЦЭХ-ний шөнийн түгээлтийн гүйцэтгэл 30.9 хувиар буюу 1,650.5 мян кВт.ц-аар нэмж түгээснээс шалтгаалсан байна.
- Газрын төлбөр 0.7 сая төгрөгөөр төгрөгөөр илүү зарцуулсан нь Нийслэлийн засаг даргын 2019 оны 07 сарын 09-ний өдрийн А/702 тоот шийдвэрээр СХД-ийн 32 дугаар хороонд шинэ үнсэн сангийн 4 га газрыг 15 жилийн хугацаатай газар эзэмших эрхийн

гэрчилгээ авч гэрээ байгуулснаас шалтгаалсан байна. 2019 оны сүүлийн хагас жилийн төлбөр 0.7 сая төгрөгийг төлсөн байна.

- Түлшний зардал 583.3 сая төгрөгөөр хэмнэсэн нь нүүрсний илчлэгийн зөрүүгээс 13.5 мянган тн нүүрс хэмнэснээс 420.0 сая төгрөг, галалгаанд 60 тонн дизель түлш түлэхээр төлөвлөснөөс үндсэн тоноглолын зогсолтын бууралтаас 9.9 тонн дизель түлш хэрэглэж 50.1 тонн дизель түлш хэмнэснээс 112.5 сая төгрөг, вагон ашиглалтын зохицуулалтыг сайн хийснээр 17.0 сая төгрөгийг тус тус хэмнэж 1 тонн нүүрсний тээврийн зардал 355.6 төгрөгөөр, тээврийн хөлсний зардал 32.8 сая төгрөгөөр өссөнөөс тус тус шалтгаалжээ.
- Цалин, НДШ-ийн зардал 265.5 сая төгрөгөөр хэмнэсэн нь үндсэн цалинг 56.9 сая төгрөгөөр, нэмэгдэл цалинг 102.5 сая төгрөгөөр, сарын үр дүнгийн шагналт цалин 73.9 сая төгрөгөөр хэмнэснээс тус тус шалтгаалсан байна. Энэ хэмнэлт нь дараах шалтгаантай.
 - ✓ 2019 онд 35 ажилтан шинээр ажилд орж 3-5 сарын дагалдангийн хугацаанд цалинжсанаас үндсэн цалин 24.8 сая төгрөг, дутуу орон тооны хэмнэлтээс үндсэн цалин 32.1 сая нийт 56.9 сая төгрөгийн цалин хөлсний зардал хэмнэсэн.
 - ✓ Ажлаас болон тэтгэвэрт гарсан 31 ажилтны удаан жилийн нэмэгдлийн хэмнэлт 102.5 сая төгрөг болсон.
 - ✓ Дагалдан ажилтнуудын сарын үр дүнгийн шагналын хэмнэлт 73.9 сая төгрөг болсон зэрэг нь нөлөөлсөн.

Цахилгаан эрчим хүч түгээлтийн хэмжээг 0.1 сая кВт.ц-аар илүү түгээснээр 15.7 сая төгрөгийн, дундаж тарифын зөрүүгээс 119.7 сая төгрөгийн, дулааны эрчим хүч түгээлтийн хэмжээг 20.3 мян.Гкал-аар илүү түгээснээр 248.9 сая төгрөгийн, дундаж тарифын зөрүүгээс 133.7 сая төгрөгийн илүү борлуулалт хийснээр нийт дүнгээр 529.1 сая төгрөгөөр орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлж, зардлыг 1,401.4 сая төгрөгөөр хэмнэснээр 304.5 сая төгрөгийн ашигтай ажиллажээ.

2.10. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд 19 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 10 эрсдэл тодорхойлж нийт 14 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 145.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 13.9 сая төгрөгийн алдааг залруулж, 131.6 сая төгрөгийн зөрчилд давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө. Үүнд:

- Тайлант хугацаанд зарцуулсан нүүрсийг 9.4 сая төгрөгөөр дутуу тооцоолж зардалд бүртгэж тайлагнасан нь “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”-ийн 5 дугаар зүйл 5.1.3 “жинхэнэ хэрэгжилтийн; 5.1.4 “үнэн зөв байх” гэсэн заалтуудтай гэсэн заалтуудтай нийцээгүй оршин байх ба иж бүрэн гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулсан.

- Тайлант хугацаанд тооцсон ерөнхий удирдлагын зардалд 4.5 сая төгрөгийн зардал илүү тусгасан нь “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”-ийн 5 дугаар зүйл 5.1.3 “жинхэнэ хэрэгжилтийн; 5.1.4 “үнэн зөв байх” гэсэн заалтуудтай гэсэн заалтуудтай нийцээгүй үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулсан.

- Тус станц тайлант үеийн элэгдлийн зардлыг нь 131.6 сая төгрөгөөр зөрүүтэй тооцоолж тайлагнасан нь “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”-ийн 5 дугаар зүйл 5.1.3 “жинхэнэ хэрэгжилтийн; 5.1.4 “үнэн зөв байх” гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн ба үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 131.6 сая төгрөгийн алдаа, зөрчилд нэг зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар дотоодын нэгжүүдэд хэрэглэж байгаа цахилгаан эрчим хүч, уур ус дулааны тооцооллыг зохих хууль, дүрэм, журам заавартай нийцэж байгаа эсэхийг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Дулааны хоёрдугаар цахилгаан станц ТӨХК нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн <http://www.tpp2.mn> цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлж байна. Тайлант хугацаанд шилэн дансны стандартыг баримтлан шилэн дансны сайтад мэдээллийг хуулийн хугацаанд үнэн зөв оруулж дараах мэдээг хүргэсэн байна. Тайлант жилд шилэн дансны цахим хуудсанд нийт 62 төрлийн мэдээллийг байршуулахаас 100 хувь хуулийн хугацаанд байршуулсан байна.

2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 4 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

2.14. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дулааны хоёрдугаар цахилгаан станц ТӨХК -ийн 2019 оны санхүүгийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Залруулагдаагүй 131.6 сая төгрөгийн алдаа, зөрчлийн дүн бидний тогтоосон 248.6 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул зөрчилгүй санал дүгнэлт өгч байна.

Дулааны хоёрдугаар цахилгаан станц ТӨХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Балансын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт

Үндсэн хөрөнгийн тайлант үеийн элэгдлийг 131.6 сая төгрөгөөр зөрүүтэй тооцоолж тайлагнасан нь “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”-ийн 5 дугаар зүйл 5.1.3 “жинхэнэ хэрэгжилтийн; 5.1.4 “үнэн зөв байх” гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.1.2 Эрсдэл

Санхүүгийн тайлан, үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал, тайлант үеийн үр дүн буруу илэрхийлэгдэх;

3.1.3 Өгсөн зөвлөмж

Үндсэн хөрөнгийн элэгдлийн тооцооллыг холбогдох стандарт, хуулийн дагуу үнэн зөв тооцож байх;

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 10-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.4.1 Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	344,745,471.23	367,636,375.76
1.1.2	Дансны авлага	1,151,249,165.71	1,796,580,485.35
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	-	9,740,442.65
1.1.4	Бусад авлага	13,089,880.27	4,452,233.60
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	-	-
1.1.6	Бараа материал	1,121,413,897.53	1,388,229,481.15
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	29,186,868.51	70,055,006.91
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	-	-
1.1.10			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	2,659,685,283.25	3,636,694,025.42
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	-	-
1.2.1	Үндсэн хөрөнгө	36,069,239,051.30	25,883,473,413.97
1.2.2	Биет бус хөрөнгө	18,804,532,733.89	18,803,072,733.29
1.2.3	Биологийн хөрөнгө	-	-
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	-	-
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	-	-
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	-	-
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	-	-
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	-	-
1.2.9			
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	54,873,771,785.19	44,686,546,147.26
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	57,533,457,068.44	48,323,240,172.68
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	1,159,394,634.67	1,433,511,795.58
2.1.1.2	Цалингийн өглөг	-	-
2.1.1.3	Татварын өр	80,266,418.95	40,871,776.71
2.1.1.4	НДШ–ийн өглөг	-	47,965.05
2.1.1.5	Богино хугацаат зээл	-	-
2.1.1.6	Хүүний өглөг	-	-
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	-	-
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	-	-
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/	-	-
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	-	-
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)-нд хамаарах өр төлбөр	-	-

2.1.1.12			
	Богино хугацаат өр төлбөрийн дүн	1,239,661,053.62	1,474,431,537.34
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	565,039,976.05	523,156,911.99
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/	-	
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	-	
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	-	
2.1.2.5			
	Урт хугацаат өр төлбөрийн дүн	565,039,976.05	523,156,911.99
2.2	Өр төлбөрийн нийт дүн	1,804,701,029.67	1,997,588,449.33
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:-төрийн	1,821,344,502,78	11,797,535,542.78
2.3.2	- хувийн	-	
2.3.3	- хувьцаат	-	
2.3.4	Халаасны хувьцаа	-	
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	-	
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	10,792,098,755.60	10,176,880,577.59
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	44,179,359,216.56	24,495,500,366.92
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(1,064,046,436.17)	(144,264,763.94)
2.3.10			
2.3.11	Эздийн өмчийн дүн	55,728,756,038.77	46,325,651,723.35
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	57,533,457,068.44	48,323,240,172.68

4.2 Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан

2019 оны 12 дугаар сарын 1-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	22,196,318,452.54	24,680,626,996.67
2	Борлуулалтын өртөг	20,032,452,717.65	21,408,448,591.97
3	Нийт ашиг(алдагдал)	2,163,865,734.89	3,272,178,404.70
4	Түрээсийн орлого	23,460,799.96	26,480,322.67
5	Хүүгийн орлого	27,734,753.54	17,012,456.61
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого	295,179,267.07	135,751,412.71
9	Борлуулалт, маркетингийн зардал	25,305,270.18	14,246,708.09
10	Ерөнхий ба удирдлагын зардал	2,441,518,241.56	2,877,353,171.04
11	Санхүүгийн зардал	14,128,514.53	13,290,853.24
12	Бусад зардал	-	-
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	12,369.11	3,957.03
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(11,267,054.78)	(34,704,989.91)
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг (алдагдал)	(241,182,277.89)	(205,566,091.56)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(223,148,434.37)	306,264,739.88
19	Орлогын татварын зардал	2,773,475.35	1,701,245.66
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(225,921,909.72)	304,563,494.22
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(225,921,909.72)	304,563,494.22
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
23.3	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн		
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

4.3 Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2017 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,821,344,502.78	11,150,810,461.72	24,169,491,363.84	(771,117,762.68)	36,370,528,565.66
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	(67,006,763.77)	(67,006,763.77)
3	Залруулсан үлдэгдэл	-	-	-	-	-
4	Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал)	-	-	-	(225,921,909.72)	(225,921,909.72)
5	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
6	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	20,009,867,852.72	-	20,009,867,852.72
7	Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	(358,711,706.12)	-	-	(358,711,706.12)
9	2018 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл	1,821,344,502.78	10,792,098,755.60	44,179,359,216.56	(1,064,046,436.17)	55,728,756,038.77
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	615,218,178.01	615,218,178.01
11	Залруулсан үлдэгдэл	-	-	-	-	-
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	304,563,494.22	304,563,494.22
13	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
14	Өмчид гарсан өөрчлөлт	9,976,191,040.00	-	(19,683,858,849.64)	-	(9,707,667,809.64)
15	Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	(615,218,178.01)	-	-	(615,218,178.01)
17	2019 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	11,797,535,542.78	10,176,880,577.59	24,495,500,366.92	(144,264,763.94)	46,325,651,723.35

4.4 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	20,249,316,754.69	23,219,122,599.32
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	19,848,706,584.30	22,930,428,648.21
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	67,388,157.00	55,821,689.00
1.1.4	Буцаан авсан албан татвар	-	-
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	-	-
1.1.6	Бусад мөнгөн орлого	333,222,013.39	232,872,262.11
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	19,510,642,950.26	22,818,671,794.26
1.2.1	Ажиллагчдад төлсөн	5,915,685,468.26	6,456,739,342.27
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	1,690,780,323.95	2,002,515,356.61
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	2,201,948,816.60	5,588,672,325.69
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	423,047,459.45	582,367,343.93
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	7,033,679,353.14	5,459,846,526.32
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн	-	62,500.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	1,520,718,745.07	1,930,513,169.60
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	11,996,431.00	2,117,910.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	712,786,353.01	795,837,319.84
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	738,673,804.43	400,450,805.06
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	27,734,753.54	14,302,563.19
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	-	-
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	-	-
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	27,734,753.54	14,302,563.19
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг	-	-
2.1.8			
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	579,951,599.10	391,866,420.75
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	579,951,599.10	391,866,420.75
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	-	-
2.2.6			
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(552,216,845.56)	(377,563,857.56)

3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	14,679.41	4,764.51
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.1.3	Төрөл бүрийн хандив		
3.1.4	Бусад	14,679.41	4,764.51
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	37,322,107.25	807.48
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	28,110,496.95	-
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	-
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	-	-
3.2.4	Төлсөн ногдол ашиг	9,209,300.00	-
3.2.5		2,310	807.48
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(37,307,427.84)	3,957.03
4	Валютын ханшийн зөрүү		
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	149,149,531.03	22,890,904.53
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	195,595,940.20	344,745,471.23
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	344,745,471.23	367,636,375.76

4.5 Аудит хийсэн 2019 оны зорилтот түвшингийн үзүүлэлтийн биелэлт

(сая төгрөгөөр)

Үзүүлэлт		төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Нийт орлого		24,330.7	24,859.8	529.1	102.2
Үүнээс: Цэвэр борлуулалт		24,162.7	24,680.6	517.9	102.1
Нийт зардал		25,956.7	24,545.9	(1,410.8)	94.6
Үүнээс: Удирдлагын зардал		290.9	283.9	(7.0)	97.6
Татварын өмнөх ашиг / алдагдал /		(1,626.0)	313.9	1,939.9	(19.3)
Цэвэр ашиг / алдагдал /		(1,626.0)	313.9	1,939.9	(19.3)
Төрийн өмчийн ногдол ашиг					
Борлуулалтын 1 төг-т ногдох зардал		1.1	1.0	(0.1)	92.6
Авлага		1,500.0	1,810.7	310.7	120.7
Өглөг		2,116.2	1,997.6	(118.6)	94.4
Үүнээс: Богино хугацаат өглөг		1,593.0	1,474.4	(118.6)	92.6
Их засвар, ТЗБАХ, хөрөнгө оруулалт		2,342.8	2,082.2	(259.6)	88.9
Жишмэл түлшний зарцуулалт	ЦЭХ	651.0	(28.4)	622.6	95.6
	ДЭХ	202.6	(0.3)	202.3	99.9
Аваар, саатал		-	2	-	-

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	“Дулааны хоёрдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудит	Аудитын код:
2020.03.13			САГ-2020/35/СТА-ТӨХК
Шалгагдсан байгууллагын нэр:	“Дулааны хоёрдугаар цахилгаан станц” ТӨХК		сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Үндсэн хөрөнгийн тайлант хөрөнгийн элэгдлийг хугацааны байгуулсан илүү	131.6	Зөвлөмж өгөх	Ерөнхий нягтлан бодогч	С.Хангал-Эрдэнэ
	Дүн	131.6			